



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/79

Ховд

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэргийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хилийн бүс нутагт коронавирусийн халдварын тархалт нэмэгдэх, экспорт, импортын үйл ажиллагаа тасалдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Булган, Үенч сумдад тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг түр хугацаанд сунгаж, бусад сумдын нутагт тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн цуцалсугай.

2. Булган, Үенч сумдын нутагт өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг хэвээр үлдээсэнтэй холбогдуулан захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Б.Алтанбадралт), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Мөнхболд), Мэргэжлийн хяналтын газар (П.Эрдэнэчулуун), Булган, Үенч сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Б.Алтанбадралт)-т үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/874 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 04-1
D/Zah-A/79-Bo